



# ЭЗБШӨЧ ТӨСЛИЙН САР ТУТМЫН ЦУВРАЛ

2005 оны 7,8 дугаар сар

## ЖДҮ-ийг санхүүжүүлэхэд АНУ-ын ОУХА-ийн Хөгжлийн Зээлийн Газрын зээлийн баталгааны бүтээгдэхүүн тохиромжтой эсэх талаар хийсэн техник, эдийн засгийн судалгаа

Монголын бүх салбарын жижиг, дунд үйлдвэрүүд (ЖДҮ)-эд дотоодын арилжааны банкнуудаас олгож буй зээлийн хэмжээг нэмэгдүүлэхэд дөхөм үзүүлэх зорилгоор энэ оны 7 дугаар сарын 18-ны өдрөөс 8 дугаар сарын 5-ны хооронд АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (ОУХА)-ийн Хөгжлийн Зээлийн Газар (ЗХГ)-ын зээлийн баталгааны бүтээгдэхүүнийг ашиглах боломжийн талаар уг төслөөс техник, эдийн засгийн судалгаа хийлээ.

АНУ-ын ОУХА-ийн ЗХГ-аас дараахь дөрвөн төрлийн баталгаа олгодог. Үүнд:

1. *Зээлийн багцад гаргах баталгаа (Loan Portfolio Guarantees)* нь "зээлдэгч"-ийг тодорхой төрлийн зээл авч буй эсхүл багц зээл авч буйгаас хамааран тодорхойлно. Тухайн зээлдүүлэгч буюу зээлдүүлэгчдийн бүлэг зээлдэгчдэд олгосон багц зээлийн 50 хүртэлх хувьд гаргах баталгааг хэлнэ.

2. *Зээлийн баталгаа (Loan Guarantees)* нь зээлдүүлэгч болон зээлдэгчийг хоёуланг нь тодорхойлж баталгааг нэг удаа эсвэл хэсэгчлэн гаргах хувилбарыг санал болгодог бөгөөд үндсэн зээлийн 50 хүртэлх хувьд баталгаа гаргадаг.

3. *Шилжүүлж болох баталгаа (Portable Guarantees)* гэж зээлдэгчид хамгийн тохиромжтой нөхцөлтэй зээлийг хайж олох боломжийг бүрдүүлж, үндсэн зээлийн 50 хүртэлх хувьд баталгаа гаргахыг хэлнэ.

4. *Бондын баталгаа (Bond Guarantees)* нь хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх зорилгод хүчтэй нөлөөлөх аргыг санал болгохоос гадна бондын зэрэглэлийг дээшлүүлж боломжит бонд худалдан авагчдын үндсэн бондын хэмжээний 50 хүртэлх хувьд баталгаа гаргахыг хэлнэ.

АНУ-ын ОУХА-ийн ЗХГ нь ЖДҮ-үүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлдэг бусад доноруудаас арилжааны зарчмаар үйл ажиллагаа явуулдгаараа ялгаатай, зах зээлд түшиглэсэн баталгаа гаргадаг механизм юм. Тухайлбал:

- ЗХГ нь үндсэн зээлийн цэвэр алдагдлын 50 хүртэлх хувьд зөвхөн хэсэгчилсэн баталгаа гаргадаг
- Хувийн салбарын зээл олгогчид өөрсдийн хөрөнгийг зээл олгоход ашигладаг бөгөөд гаднаас зээлийн эх үүсвэр олгодоггүй

- Зээл олгогч нь өөрийн баримталдаг зээлийн бодлогод тулгуурлан шийдвэр гаргадаг
- Зээл олгогч нь зээлийн хүүгийн хэмжээг зах зээлийн дагуу тогтооно
- ЗХГ-ын баталгаануудыг катализаторын адил ашигладаг бөгөөд зах зээлд нэвтрүүлэх баталгааны загварыг бий болгох ёстой.

7, 8 дугаар сард Кемониксийн зээлийн баталгааны зөвлөх Кэрри Аверч, Ирина Седова нар ЭЗБШӨЧ төслийн санхүүгийн багтай нягт ажиллаж зээлийн нөхцөл, байдал, ЖДҮ-ийн санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ хүртэх боломжийг хязгаарлаж буй зах зээлийн сул талуудын талаар дүн шинжилгээ хийв. ЖДҮ-ийн зээлийн эрэлт хэрэгцээ, нийлүүлэлтийг тус багийнхан мөн судлаж үзжээ.

ЖДҮ-ийн зээлийн эрэлт хэрэгцээний хувьд 211 ЖДҮ-ийн зээлийн өргөдлийг нягтлан үзэж, зээлийн дундаж хэмжээ,




зээлийн нөхцөл мөн зээлийн хүүгийн дундаж хэмжээг судлав. Зээлийн нийлүүлэлтийн хувьд ЗХГ-тай түншлэн ажиллаж болох 8 арилжааны банкны талаар урьдчилсан мэдээлэл цуглуулж тэдний ЖДҮ-т үзүүлэх зээлийн стратеги, чадвар мөн ЗХГ-ын баталгааны хөтөлбөрт оролцох хүсэл сонирхолтой эсэхийг хянаж үзсэн байна.

Үүнээс гадна ЖДҮ-ийг хөгжүүлэх, санхүүжүүлэх үйл ажиллагаа явуулж буй бусад олон улсын донор байгууллагуудын төлөөлөгчидтэй уулзаж ярилцаж, ЗХГ-ын баталгаа нь ЖДҮ-ийг дэмжих явцад шууд нөлөөлөл үзүүлэхийн хувьд бусад хандивлагчдийн хөтөлбөртэй давхцахгүй харин тэдгээрийг нөхөн нэмэлт болж, цаашид ЖДҮ-эд урт хугацааны зээл олгох нь ашигтай гэдгийг зах зээл дээр харуулах нь чухал байлаа.

8 дугаар сарын 5-нд судалгааны урьдчилсан дүнгийн талаар танилцуулав. Өнөөгийн эдийн засгийн нөхцөл мөн бусад доноруудын үйл ажиллагааг анхааран үзэж одоогийн байдлаар ЗХГ-ын Зээлийн багцад гаргах баталгаа, Бондын баталгааны аль нь ч ЖДҮ-эд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, үйл ажиллагааг өргөтгөх зорилгоор олгох банкны дунд хугацааны зээлийг нэмэгдүүлэхэд одоогоор тохиромжтой бус гэсэн дүгнэлтийг багийн гишүүд гаргав. Дараахь үндэслэлийн улмаас энэхүү дүгнэлтийг гаргажээ. Үүнд:

- ЗХГ нь түнш банкуудыг зөвхөн өөрийн хөрөнгөөс зээл өгөхийг шаарддаг. Гэтэл Монголын банкуудын ЖДҮ-эд урт хугацааны зээл олгох хөрөнгийн сан нь маш хязгаарлагдмал байна.
- Дэлхийн банк, KfW, болон JВIC нь хоёр шатлалтай зээлийн хөтөлбөрийг санал болгож байгаа бөгөөд хүүгийн хэмжээ нь хугацаагүй хадгаламжийн хүүгийн хэмжээнээс доогуур байх юм байна. Ингэснээр зээлийн эдгээр боломжийг ашиглах сонирхол банкуудад төрнө гэж үзэж байна



- ЖДҮ-д чиглэсэн донорын хөрөнгийн хэмжээг харгалзаж үзвэл эдгээр хөтөлбөрүүдийн зэрэгцээ ЗХГ-ын зээлийн багцад гаргах баталгаа нь зээлийн зах зээлийн сул талыг арилгахад нөлөөлж чадахгүй бөгөөд ЗХГ-аас тавьж буй шаардлагын дагуу зах зээлд нэвтрүүлэх баталгааны жишиг загвар болж чадахгүй юм.

Үүний оронд ЗХГ-ын Зээлийн баталгааг цаашид ашиглах боломжийн талаар судлан үзэж гадаадын санхүүгийн байгууллагаас олгож буй дунд хугацааны зээлийг баталгаажуулж хязгаарлагдмал тооны банкинд тусалцаа үзүүлж, дотоодын нөөцөөс дунд хугацааны зээлийн санхүүжилтийн хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэхэд тус дөхөм үзүүлж болох боломжийн талаар багийнхан зөвлөмж гаргажээ. Монголын банкинд олон улсын зээл олгогчоос олгох үндсэн зээлийн 50 хүртэлх хувьд баталгаа гаргаснаар зээлийн энэхүү баталгаа нь дараахь ач холбогдолтой. Үүнд:

- Монголын дотоодын банкуудын төлбөрийн чадварын баталгааг олон улсын үнэлгээний оронд бий болгоно.
- Монголын дотоодын банкуудыг урт хугацаатай хөрөнгийн тогтвортой эх үүсвэрээр хангаж, улмаар хөрөнгийн бүтцийг өөрчлөх, урт хугацааны зээлийг нэмэгдүүлэх боломж бий болгоно.
- Монголын банкуудын ил тод байдал, олон улсын хэмжээнд төлбөрийн чадвартай болохыг зах зээлд харуулах үлгэр жишээ үйл ажиллагаа болно

ЗХГ-ын зээлийн баталгааны хөтөлбөрийг холбогдох байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагаатай хослуулан хэрэгжүүлвэл Монголын банкны салбарыг ЖДҮ-эд олгох зээлийн тогтвортой эх үүсвэрээр хангаж, урт хугацааны хөрөнгө бий болгож, санхүүгийн зах зээлийн өнөөгийн сул талуудыг арилгахад хувь нэмэр оруулж, улмаар Монголын банкны салбарын хөгжилд зэрэг шууд нөлөө үзүүлнэ.

## 14,000 гаруй жуулчид Жуулчны мэдээллийн төвөөр үйлчлүүлжээ

Төв шуудангийн байранд 5 сарын өмнөөс үйл ажиллагаагаа эхэлсэн Жуулчны мэдээллийн төвөөр (ЖМТ) 8,500 гаруй жуулчид үйлчлүүлсэн гэсэн мэдээлийг жуулчны бүртгэлийн дэвтрээс харж болох аж. Үүнээс гадна онгоцны болон галт тэрэгний буудал дахь төвүүдээр 3,000 орчим хүн үйлчлүүлжээ. Зам, тээвэр, аялал жуулчлалын яам, Монголын Урлагийн холбоо



болон Монголын Аялал жуулчлалын холбооны хамтын хүчээр байгуулагдсан ЖМТ нь 2005 оны 4 дүгээр сард нээгдэж тун удалгүй онгоц болон галт тэрэгний буудал дээр салбараа байгуулжээ. Тус төвийн үйл ажиллагааг эхлүүлж ажилтнуудыг бэлтгэхэд ЭЗБШӨЧ төслөөс санхүүгийн болон техникийн тусалцаа үзүүлсэн юм.

8 дугаар сарын сүүлээр үйлчлүүлэгчдийн санал гомдлын талаар хийсэн судалгаанд ажилтнуудын элэгсэг харьцаа, тусч байдал, үйлчилгээний шуурхай байдал, үнэн зөв мэдээлэл, ажилтнуудын англи хэлний мэдлэг чадвартай холбоотой асуултуудыг багтаажээ. Ихэнх гомдол төвийн эзлэж буй байрны багтаамж жижиг, ажилтнуудын цөөн тоо, мөн хүн ихтэй үед хүлээлгэх асуудалтай холбоотойгоор гарчээ.

Одоогийн байдлаар уг төв нь 150 аялал жуулчлалын компани, 30 гаруй олон нийтийн байгууллагын талаар мэдээллээр хангадаг бөгөөд үзвэрийн тасалбар

худалдахад Улсын филармонитой хамтран ажиллаж зочид буудлуудын ваучерыг тодорхой хувь авах нөхцөлтэйгээр зуучлах байдлаар түншлэж ажиллаж байгаагаас гадна "хот танилцуулга"-ыг санал болгох байдлаар тур операторуудтай хамтран ажиллаж байна. Үүнээс гадна Урлагийн холбоотой хамтран үзвэр үйлчилгээний талаарх мэдээллийн "What's on" танилцуулгыг тогтмол хэвлэн тарааж байна.

## Үндэсний диспетчерийн төвд программ хангамжийн сургалтыг зохион байгуулав

Үндэсний диспетчерийн төвийн 7 ажилтанд зориулж ЭЗБШӨЧ төслөөс 6 хоногийн програм хангамжийн сургалт зохион байгуулав. Сургалтын явцад дамжуулах/түгээх тогтолцооны тогтвортой байдлыг хангах, оновчтой загварыг нэвтрүүлэх, эрчим хүчний тасалдалтаас урьдчилан сэргийлэх, гарах үр дагаврыг багасгахад тус дөхөм болох багц программыг ашиглах талаар заажээ.



Энэхүү программыг нийлүүлэгч Siemens Technologies, Inc. of Schenectady, NY, нь уг төсөлтэй сургалт зохион байгуулах талаар гэрээ байгуулан ажлыг гүйцэтгэв.

## Татварын талаархи Засгийн газрын саналыг олон нийтэд хүргэж хэлэлцүүлэх ажлыг төслөөс дэмжиж байна.

Өнгөрсөн 7,8 дугаар саруудад Сангийн Яам, Үндэсний Татварын Ерөнхий Газраас (ҮТЕГ) татварын шинэтгэлийн талаархи цуврал хэлэлцүүлгийг долоо хоног тутам гарган, сонин хэвлэлд нийтлүүлээ. Доорхи сэдвээр нийт 10 хэлэлцүүлгийг өдөр тутмын 4 томоохон сонинд нийтэллээ. Үүнд

- Ажлын байр, эдийн засгийн өсөлтөд чиглэсэн татварын хөнгөлөлт (6 дугаар сарын 20)
- Хүн амын орлогын албан татвар (6 дугаар сарын 27)
- Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татвар (7 дугаар сарын 4)
- Татварын "сайн" тогтолцоо гэж юу вэ? (7 дугаар сарын 18)
- Монголын нэмэгдсэн өртгийн албан татвар (VII/25)
- Татварын шинэтгэлийг яагаад хийх ёстой вэ? хаанаас эхлэх вэ? (8 дугаар сарын 1)

- Татварын шинэтгэлийг яагаад хийх ёстой вэ, хаанаас эхлэх вэ? II хэсэг Нэмэгдсэн өртгийн албан татвар (8 дугаар сарын 15)
- Татварын шинэтгэл хийх оролдлого өрнөж байна (8 дугаар сарын 21)
- Хүн амын орлогын албан татвар I хэсэг (8 дугаар сарын 29)
- Хүн амын орлогын албан татвар II хэсэг (9 дүгээр сарын 5)

Эдгээр цуврал хэлэлцүүлгийг хэвлэхэд уг төслөөс Сангийн Яам, ҮТЕГ-ын хэвлэл мэдээллийн төлөөлөгчидтэй нягт хамтран ажиллав.

Долоо хоног тутам гаргаж буй эдгээр цуврал нь энэ оны эхээр Засгийн газрын хүсэлтээр уг төслөөс боловсруулсан татварын шинэтгэлийн талаарх олон нийтийн мэдээлэл харилцааны стратегийн нэг хэсэг бөгөөд УИХ-ын намрын чуулганаар татварын багц хуулийг батлах хүртэл тогтмол нийтлэгдсээр байх болно. Олон нийтийн мэдээлэл харилцааны кампанит ажлын зорилго татварын талаар монголчуудын боловсролыг дээшлүүлэх, татварын шинэтгэлийн талаар Засгийн газраас хэрэгжүүлж буй янз бүрийн арга хэмжээний талаар олон нийтэд мэдээлэхэд чиглэж байна.



**Татварын талаархи илэн далангүй яриа**

**УИХ-д өргөн барьсан хүн амын орлогын албан татварын хуулийн төсөл**



**II Хэсэг: Хуулийн талаарх нэмэлт мэдээлэл**

Хүн амын орлогын албан татварын хуулийн төсөлд татварын хувь, хэмжээнд өөрчлөлт оруулахад хувь, хэмжээний орлогын аж үйлдвэрийг илүү олон талаас нь авч үзсэн байна. Энэ нь хуулийг олон улсын жишигт нийцүүлэн өөрчлөх юм. Хуулийн эдгээр өөрчлөлтөй хамтанд баталснаар Засгийн газар эдийн засгийн өсөлтийг хангах, түүний үзүүлэлтийг илүүтэй өндөр хангах юм. Дараах өөрчлөлтүүдийг хуулийн төсөлд тусгасан байна.

- Хуулийн нэг мөр өйтөх зорилгоор хуулийн зарим нэр томъёог тайлбарласан заалтыг хуулийн төсөлд тусгав. Үүний үр дүнд татвар төлөгчийн статус тодорхой болж ажилтай хэмжээний орлогын албан татварыг төлөх боломжтой болно. Тухайлбал, малчин өрх, мал буйх өртгөлд, гадаад улсад олон орлого, суулгалч гэсэн нэр томъёог тайлбарласан заалтыг тусгалав.
- Сэргэйн мөрдөж байгаа хуульч татвар, бооцолт тогтоомь эд мөнгөний хэмжээг сугалааны хөндөөр оролдож ногдуулах албан татвар нь аж ахуйн нэгжийн хувьд 40, иргэний хувьд 10 хувиар тус тус тогтоосон байдаг. Энэ журмыг байдлыг өөрчлөх зорилгоор уг орлогод 30 хувиар албан татвар ногдуулж байхад хүн амын орлогын албан татварын хуулийг шинэчлэн найруулав байна. Үүний үр дүнд иргэдийн бооцолт тогтоомь оролцоо бүрэн аажмаар аж ахуйн нэгжид үг үйл ажиллагаа шилжих юм.
- Хуулийн төсөлд оршин суугч болон оршин суугч бус албан татвар төлөгчийн ялгааг сайтар тайлбарласан бөгөөд үргэлжлэн 183 ба түүнээс дээш хоног Монгол Улсад оршин сууж байгаа гадаадын иргэн харьяалалгүй хүнийг оршин суугч эгтээд хамаруулахад тусгасан байна. Энэ нь бүх оршин суугч татвар төлөх гадаад улсад олон орлогоо татвар төлөх тухай чухал заалт юм. Харин оршин суугч бус татвар төлөх нь зөвхөн Монгол Улсын нутаг дэвсгэрт олон орлогоо албан татвар төлөх.
- Хуулийн төсөлд өнх удаа орлогыг түүний аж үзвэрээр нь ангилсан. Ерөнхий ангилал нь үндсэн болон үндсэн бус орлогоос бүрдэж байна. Үндсэн бус орлогод шалт, мэдээллийн хаяг, хувь хүний хувийн чармайлтар зурвасын тогтолт, шалт, уламжлал г.м.г олон орлогоос бүрдэж орлого хамарна. Үүнийг харьяаны болон харьяаны хэдлэлийн орлого гэж ангилсан. Харьяаны орлогод тэрээс, эрхийн шалтгал, хуулийн г.м. орлого, харьяаны хэдлэлийн орлогод хэдлэх, үл хэдлэх хөрөнгө, хувьцаа, үнэт цаас борлуулалт орлогод хамарна.
- Хуулийн төсөлд шууд бус орлогыг тодорхойлж тусгалав. Энэ нь ажил олгогчоос ажилтандаа шалт, хаяг, шалчлалас гадна олгож буй тэтгэмж юм. Тухайлбал, үзвэр үйлчилгээ, эмнэлэг, орон сууц, тээврийн хэрэгсэл ашиглуулах төлбөр зэрэг үнд хамарна. Харин энэ орлогод албан татвар ногдуулж нь иргэдийн татварын дарамт болохоор байсаар харгалзан татваргаас чөлөөлөх орлогод хамаруулах нь зүйтэй гэж Засгийн газар үзэв.
- Зарим аж ахуйн нэгж, байгууллагууд ажилтандаа хоол, тээврийн зардал, чөлөөлтийг шалтанд нь тооцон олгодог. Амьтны татварын дарамтыг бууруулах зорилгоор уг заалтыг харахуудад, Үүнийг бүх аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд ашигтай байхад үүрэгжүүлж ажиллыг хуулийн төсөлд хэсэг хөнгөлөлтөд татвар ногдуулахаар болсон байна. Харин аж ахуйн нэгжийн хувьд энэ зардал нь татваргаас хасгахад зардал байх юм.

Татвар талаарх өргөн барьсан хуулийн төсөл "Нээлттэй засаг" вэб сайт [www.open-government.mn](http://www.open-government.mn) (Монгол, Англи хэл) болон Улсын Их Хурлын вэб сайт [www.ih.gov.mn](http://www.ih.gov.mn) (Монгол хувь)-аас үзэж болно. Иргэдийн санал авах зорилгоор дор дурдсан вэб сайтгаас гадна өмнө танин болсон буцаад вэб сайтүүдийг үг нийтлэлийг мөн гаргаж байгаа юм. Та бүхэн санал, саналгаа үлдэнэ үү.

Энэхүү мэдээлэл нь татварын шинэтгэлийн талаар нийт ярих иргэдийн санал бодлыг сонсох зорилгоор Сангийн Яам, Үндэсний Татварын Ерөнхий Газраас явуулж буй цуврал хэлэлцүүлгийн эрхэндгээр хэсэг юм. Та бүхэн уг цувралын алектрон хувилбарыг "Нээлттэй засаг" вэб сайт ([www.open-government.mn](http://www.open-government.mn)), Сангийн Яамны вэб сайт ([www.mta.gov.mn](http://www.mta.gov.mn)), ҮТЕГ-ын вэб сайт ([www.mta.gov.mn](http://www.mta.gov.mn))-аас үзэж, саналаа ирүүлж болно.

Татварын талаархи эдгээр цуврал нь олон нийтэд зориулагдсан татварын гарын авлага маягийн авсаархан сургалтын танилцуулга материал болж болох бөгөөд татварын шинэтгэлийн явцад оролцож буй бодлого боловсруулагчдад мөн тус дөхөм болно гэж үзэж байна. Цувралыг өдөр тутмын сонинд хэвлэхээс гадна дараахь вэб сайтуудад байрлуулсан болно:

- ҮТЕГ: [www.mta.mn](http://www.mta.mn)
- Сангийн Яам: [www.mof.pmis.gov.mn](http://www.mof.pmis.gov.mn)
- Нээлттэй Нийгэм Форум: [www.forum.mn](http://www.forum.mn)
- ЭЗБШӨЧ Төсөл: [www.eprc-chemonics.biz](http://www.eprc-chemonics.biz)
- Оллоо: [www.oloo.mn](http://www.oloo.mn)
- Монголын Хөгжлийн Гарц: [www.gateway.mn](http://www.gateway.mn)
- Нээлттэй Засаг: [www.open-government.mn](http://www.open-government.mn)

## Энэ оны эхний хагаст Монголд инфляцийн түвшин дахин өсч эхэллээ

Үндэсний Статистикийн Газар (ҮСГ)-ын мэдээ (ҮСГ-ын сар тутмын статистикийн мэдээний товхимол, 2005 оны 6 дугаар сар)-д тулгуурлан гаргасан Зураг 1-аас харахад хэрэглээний үнийн индекс 14.2%-д хүрчээ. 2005 оны 6 дугаар сард индекс 1999 оноос хойшхи хамгийн өндөр хувь буюу 17.8%-д хүрч байсан ажээ.

Зураг 2-т 2002 оноос хойш улирал тутамд өргөн хэрэглээний барааны үнэд орсон өөрчлөлтийг харуулав. Хүнсний үнийн индекс 2002 оны 2 дугаар улиралд -7% байсан бол 2005 оны 2 дугаар улиралд +21% хүрч огцом өсчээ. Өнгөрсөн жилээс хойш монголын хүн амын гол хүнс болох махны үнэ 40 гаруй хувиар өсөөд байна. Орон сууц, халаалтын үнэ сүүлийн хэдэн улиралд тасралтгүй өслөө.

**Яагаад мөнгөний ханш унаж байна вэ?** Хөрөнгө оруулалтын эрсдэл үнийн өөрчлөлтийг дагаж өсөх хандлагатай байдаг тул инфляцийн өсөлт голдуу хөрөнгө оруулалтыг буурахад хүргэдэг. Учир нь эдийн засгийн инфляци өндөр (ба өсч) байгаа үед цаашид ашигтай ажиллах боломжтой байсан олон төсөл үйл ажиллагаагаа зогсоодог. Монголын дотоодын хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын ДНБ-д ногдох хувь (өөрсдийн эх сурвалжаас санхүүжүүлсэн) 2001 онд 4 орчим хувь байсан бол 2004 онд 3% хүртэл буурсан. Үүнийг дэлхийн хэмжээнд авч үзэхэд хамгийн доогуур үзүүлэлтүүдийн нэг юм.


Валютын ханш харьцангуй тогтвортой байх үед үнийн инфляцийн түвшин өндөр байх нь дотоодын мөнгө тэмдэгтийг хүлээн зөвшөөрөхөд хүргэдэг. Хятадад жилийн инфляцийн түвшин 1-2% байхад Монголд жилийн инфляцийн түвшин хоёр оронтой тоотой байдаг бөгөөд валютын ханш түүнд зохицож чадахгүй бол монголын бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар үнийн хувьд буурахад хүрдэг. Төмрийн хүдэр, нэхмэл эдлэлээс бусад монголын экспортын бүтээгдэхүүн 2000-2003 онд 120-180 сая орчим ам.доллар байсан бол 2003 онд 93 сая ам.доллар, 2004 онд 63 сая ам.доллар хүртэл буурсан.

Үнийн өндөр инфляци ядуу хүмүүсийн амьдралд улам дарамт үзүүлдэг. Бага орлоготой ихэнх айл өрх аажим (уян хатан биш) өсдөг орлогоос хараат байдалд байж инфляцийн нөлөөнд өртөгдөхгүй байх хөрөнгө оруулалт хийх юм уу хэрэглээнийхээ хэв маягийг өөрчлөх замаар өөрсдийгөө инфляциас хамгаалах чадваргүй тул тэд үнийн өсөлтөд хамгийн их өртөгдөх хандлагатай байдаг. Тэд ихэнх орлогоо "амьдралын хэрэгцээт зүйл"-д зарцуулдаг бөгөөд үнийн харьцангуй өөрчлөлтөд тохируулан төрөл бүрийн барааг зохицуулан хэрэглэж чадах илүү чинээлэг гэр бүл шиг дасан, зохицох чадваргүй. Өнгөрсөн жил хүнсний үнэ 21%, орон сууцны үнэ (халаалт) 13%-аар тус тус өссөн нь гэр хорооллын ядуу оршин суугчдын хувьд хамгийн хүнд цохилт болсон; хотын эдгээр оршин суугч малчид шиг хүнс, түлшээ бэлтгэдэггүй бөгөөд өөрсдийн орлогын ихээхэн хэсгийг тэдгээр амьдралын хэрэгцээт зүйлд хүргэж зарцуулах хэрэгтэй болдог.


Өндөр инфляци төсөв зохиох ажилд хүндрэл учруулдаг. Орлого, зарлагын тооцоог өгөгдсөн үзүүлэлтээр хийдэг бөгөөд инфляцийн ерөнхий түвшин, холбогдох үнэд орж болох томоохон өөрчлөлт улс төр, нийгэм, эдийн засгийн янз бүрийн хурцадмал байдлыг үүсгэж болзошгүй. Хэрэглээний үнэд том өөрчлөлт орвол эдгээр нь хүн амын албан татвар төлөгчдөд үзүүлдэг 4,000 төгрөгийн татварын хөнгөлөлт юм уу 3,000 төгрөгийн хүүхдийн тэтгэлэгт сөргөөр нөлөөлөх болно.

Шийдвэрлэхэд хамгийн түвэгтэй байж болох асуудал бол инфляцийн түвшин өндөр байгаа явдал бус харин түүний ноцтой үр дагавартай, эрчимтэй хувиран өөрчлөгдөж байдаг ерөнхий төлөв байдал юм. Өндөр инфляци нь үнийг улам илүү өсгөх хандлагатай инфляцийн талаарх урьдчилсан таамаглалыг хөхүүлэн дэмжиж байдаг. Ийм таамаглал "үнийн тасралтгүй өсөлт, бууралт"-ыг идэвхжүүлэхэд энэ нь эдийн засгийг богино хугацаанд тогтворгүй болгож болно. Инфляцийг бууруулна гэдэг


Зураг 1: Монгол дахь инфляцийн жилийн дундаж түвшин (2000 - 2005; хувь)



Зураг 2: Монгол дахь гол нэр төрлийн бүтээгдэхүүний жилийн хэрэглээний индекс гарсан өөрчлөлт (2002 - 2005; улирал тутамд; хувь)



Зураг 3: Монгол дахь бүтээгдэхүүний нийт нийлүүлэлтэд гарсан өөрчлөлт: дотоодын ба импортын бүтээгдэхүүн (2000 - 2005; хувь)



хүнд ажил юм; ихэнх тохиолдолд энэ нь ДНБ, орлого, хэрэглээ, хөрөнгө оруулалтыг бууруулдаг. Ядуу хүмүүс ийм өөрчлөлтөөс сэхээ авах гэж зүдэрдэг.

**Монгол Улсын инфляци ямар шалтгаантай вэ?**

Зураг 3-аас харахад сүүлийн үед монголын зах зээлд нийлүүлдэг бараа, үйлчилгээний нийт нийлүүлэлтийн өсөлт буурах хандлагатай байна. Бидний тооцоолж байгаагаар монголын эдийн засгийн мөнгөөр гүйлгээ хийдэг сегментэд (өөрөөр хэлбэл, айл өрхийн хэрэглэдэг өөрсдөө хийсэн хоол ба бусад бүтээгдэхүүнийг эс тооцвол) айл өрх өөрсдийн зардлын 93.5%-ийг дотоодын хоёрдогч салбар (үйлдвэрлэл, барилга), дотоодын гуравдагч салбар (үйлчилгээ), импортын бараа 8.8%, 35.8%, 48.9%-ийг тус тус хангадаг бүтээгдэхүүнд зарцуулдаг. Эдгээр салбарын бодит өсөлт тогтмол буурч байна: 2005 оны эхний хагаст үйлдвэрлэл, импортын бүтээгдэхүүний жилийн нийлүүлэлтийн хэмжээ сөрөг үзүүлэлттэй гарсан. Тээврийн зардал өндөр, мөн төсөв, мөнгөний бодлого ба бусад хүчин зүйл энэ уналтад нөлөөлсөн.

Үүнтэй нэгэн зэрэг хүмүүс, бизнесийн байгууллага, төр засгийн татварын дараахи орлого өндөр түвшинд тогтмол өсч байгааг зураг 4-т харуулжээ. Албан ёсны статистикийн мэдээгээр хувийн цэвэр орлогоос 2004 онд Монголд 174 тэрбум төгрөг буюу гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО) юмуу аль эсвэл хандивлагчдын тусламжаас илүү мөнгө орж иржээ. ГШХО, хандивлагчдын тусламжийн хэмжээ өндөр хэвээр байна. Мөн сүүлийн 3 жилд худалдааны алдагдал буурч байгаа нь банкны дансны нөөц өсөхөд түлхэц болжээ.


Түүнчлэн 2000-2004 онд банкны зээл ихээхэн нэмэгджээ. Зураг 5-т цэвэр гадаад шилжүүлэг, төсвийн орлого (татвар ба бусад татварын бус орлого) 2 дахин өсч байсан бол банкны зээл 9 дахин өссөнийг харуулжээ. Бодит хүүгийн хэмжээ буурах үед арилжааны банкны зээлийн ийм өсөлт гарч байна (Зураг 6). Одоогийн байдлаар банкны зээл дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий 1/3-тэй тэнцэх хөрөнгийг эдийн засагт оруулж байна. Жилийн дундаж бодит хүүгийн хэмжээ 2000-2002 онд 30-34% байсан бол 2005 оны эхний хагаст 13% хүртэл буурчээ. Ийнхүү татварын дараахи орлого, банкны зээл тасралтгүй өсч байгаа боловч дотоод ба импортын бүтээгдэхүүний нийлүүлэлт үнийг өсгөх хэмжээнд хүртэл нэмэгдээгүй ажээ.

2005 оны 6 дугаар сараас өмнөх 12 сарын хугацаанд хэрэглээний үнийн индекс (ХҮИ) 5%-18% хүртэл өсч байсан боловч энэ хугацаанд Монгол Банк мөнгөний ханшийг 13.3%-аас 5.5% хүртэл бууруулжээ. Хэрэглээний үнийн индексийн сүүлийн үеийн төлөв байдлад дүн шинжилгээ хийхэд ашиглаж болох нэмэлт тоо баримт гарч ирэх үед төв банк цаашид инфляцийн дарамтыг бууруулахад тус дөхөм үзүүлэх зорилгоор өөрийн мөнгөний бодлогод зохицуулалт хийх асуудлыг авч үзэж магадгүй.


**Ямар арга хэмжээ авах хэрэгтэй вэ?**

Одоогийн байдлаар төгрөгийг хүлээн зөвшөөрч бодит хүүгийн хэмжээ доогуур, төсвийн орлого, зарлага өндөр байгаа үед инфляцийн дарамт өсөн нэмэгдэж байна. Ийм үнийн тасралтгүй өсөлтөөс "зөөлөн газардах"-ын тулд инфляцийг бууруулж эдийн засгийг тогтворжуулахад чиглэгдсэн засч залруулах бодлогыг авч үзэх хэрэгцээ гарч болох юм. Харамсалтай нь хурдан нөлөө үзүүлэх мөнгөний бодлогыг засч залруулах жишиг арга хэмжээ авах нь мөнгөний ханшийг унагаж хүү огцом өсгөх, мөнгөн


**Зураг 4: Гаднаас орж ирсэн орлого, тэрбум төгрөг**



**Зураг 5: Монгол дахь нийт орлого (зарим үзүүлэлтээр) (2000 - 2005; тэрбум төгрөг)**



**Зураг 6: Монгол дахь жилийн нэрлэсэн ба бодит хүүгийн дундаж хэмжээ (2000 - 2005)**



тэмдэгтийг өндөр үнэ (илүү сонирхол татахуйц)-ээр борлуулах замаар мөнгөний нийлүүлэлтийг бууруулах зэрэг алхмыг санал болгож болзошгүй тул ийм арга хэмжээ нь хялбар бөгөөд тааламжтай зүйл биш юм.

Улсын төсвийг бууруулах, урт хугацаанд үр нөлөө үзүүлэх, үйлдвэрлэлийн хүчин зүйлийн бүтээмжийг дээшлүүлэх, үйлдвэрлэлд тохиолдож буй саад бэрхшээл, нийт зардлыг бууруулах зорилгоор дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зэрэг бүтцийн хувьд үр ашигтай засч залруулах ямар ч арга хэмжээг авахад хүндрэлтэй юм. Инфляцийн ийм чиг хандлагын хувьд сэтгэл зовоосон асуудлыг нотлох юм уу зөөлрүүлэх, засч залруулах бодлогын арга хэмжээ авахын тулд ирэх 2-3 сард гарч ирэх тоо баримтыг нухацтай авч үзэх хэрэгтэй болно.

*Энэ цуврал нь ЭЗБШӨЧ Төслийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр сар тутам мэдээлдэг хэвлэл юм. Хэрэв Та санал хүсэлт, манай цувралын захиалгад орох эсвэл гарах хүсэлт байвал ЭЗБШӨЧ төслийн цувралын эрхлэгчтэй дараахь хаягаар холбоо барина уу. Үүнд: цахим шуудан: [fbertoli@eprc-chemonics.biz](mailto:fbertoli@eprc-chemonics.biz), факс: (976-11) 32 78 25.*